

**Зөвлөл шинэчлэн байгуулах,
журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.5, 23 дугаар зүйлийн 23.2, 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3, Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах үүрэг бүхий Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /О.Мөнгөншагай/-д үүрэг болгосугай.

3.Захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Зөвлөл, Нийслэлийн Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам, Шуурхай ажлын хэсэг, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги байгуулах тухай” А/1008 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ**

С.АМАРСАЙХАН

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ
НИЙСЛЭЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч
- Орлогч дарга: Нийслэлийн Хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч
- Гишүүд: Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч
- Нийслэлийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч
- Нийслэлийн Агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч
- Нийслэлийн Инноваци технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч
- Нийслэлийн Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч
- Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /зөвшилцсөнөөр/
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн дарга
- Нийслэлийн Архивын газрын дарга
- Нийслэлийн Байгаль орчны газрын дарга

Нийслэлийн Боловсролын газрын дарга

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга

Нийслэлийн Мал эмнэлгийн газрын дарга

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга

Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга

Нийслэлийн Статистикийн газрын дарга

Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Нийслэлийн Цагдаагийн газрын дарга

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга

Монголын Улаан загалмай нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч /тохиролцсоноор/

“Дэлхийн зөн Монгол” Олон улсын байгууллагын үйл ажиллагааны захирал /тохиролцсоноор/

Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/

Шинжлэх ухаан, технологийн сургуулийн Геологи, уул уурхайн сургуулийн Эрдэс боловсруулалт, инженерчлэлийн салбарын эрхлэгч, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, судалгааны төвийн захирал /тохиролцсоноор/

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нийслэлийн Онцгой байдлын газрын дэд, Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 14-ний өдрийн
А/441 дүгээр захирамжийн
хоёрдугаар хавсралт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НИЙСЛЭЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Гамшгийн эрсдэлийг бууруулах Нийслэлийн зөвлөл (цаашид “Нийслэлийн зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Нийслэлийн зөвлөл нь гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, энэхүү журмыг удирдлага болгоно.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Нийслэлийн зөвлөлийг Нийслэлийн Засаг дарга тэргүүлж, Нийслэлийн Хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч орлоно.

2.2. Нийслэлийн зөвлөл нь Ажлын албатай байна. Ажлын албыг Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга удирдаж, ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг тус байгууллагын гамшгийн эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан нэгж гүйцэтгэнэ.

2.3. Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл нь Нийслэлийн зөвлөлийн дэд зөвлөл байх бөгөөд хэрэгжүүлсэн ажлаа тайлагнана.

2.4. Нийслэлийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад нь чиг үүргийн хүрээнд Нийслэлийн зөвлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулж ажиллана.

2.5. Нийслэлийн Зөвлөл хэвлэмэл хуудас, тамга тэмдэг хэрэглэж болно.

Гурав. Нийслэлийн зөвлөлийн бүрэн эрх

3.1. Нийслэлийн зөвлөл нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хамаарах эрхийг хэрэгжүүлнэ.

3.2. Нийслэлийн зөвлөлийн гишүүн дараах эрхтэй байна:

3.2.1. Шаардлагатай тохиолдолд Нийслэлийн зөвлөлийн ээлжит бус хуралдааныг хуралдуулах саналыг Нийслэлийн зөвлөлийн даргад танилцуулах;

3.2.2.Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, Үндэсний болон Нийслэлийн зөвлөлөөс гарсан зөвлөмжийн хэрэгжилтэд шаардагдах судалгаа, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

3.2.3.Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр эрхэлсэн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, салбар хоорондын зохицуулалтыг хангах асуудлыг Нийслэлийн зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн хуралдаанд санал хүргүүлэх;

3.2.4.Нийслэлд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлогын зөвлөмж гаргах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад чиглэл өгөх;

3.3.Нийслэлийн зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй байна:

3.3.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлсэн ажлаа Нийслэлийн зөвлөлийн хуралдаан, холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах, шаардлагатай тохиолдолд ажлын албанд хүргүүлэх;

3.3.2.Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой бодлогын зөвлөмж боловсруулах, бусад гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж салбар дундын зохицуулалтыг хангах;

3.3.3.Үндэсний болон Нийслэлийн зөвлөлөөс гарсан шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

3.3.4.Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг тухайн жилийн төсөвт тусгах санал боловсруулах.

Дөрөв. Нийслэлийн зөвлөлийн хуралдаан

4.1.Нийслэлийн зөвлөлийн ажиллах үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг Нийслэлийн зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

4.2.Нийслэлийн зөвлөлийн хуралдааны шийдвэр нь зөвлөмж байна.

4.3.Нийслэлийн зөвлөлийн ээлжит хуралдааныг жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

4.4.Ээлжит хуралдааны товыг хуралдаан болохоос 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хурлын материалыг тараасан байна.

4.5.Нийслэлийн зөвлөлийн хуралдааныг нийт гишүүдийн 51-ээс дээш хувийн ирцтэйгээр хуралдуулна. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхын саналаар, санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

4.6.Нийслэлийн зөвлөлийн даргын шийдвэрээр хуралдаанд холбогдох эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл оролцуулж болно.

Тав. Нийслэлийн зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагаа

5.1. Нийслэлийн зөвлөлийн ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1.Хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааныг зохион байгуулах;

5.1.2.Нийслэлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад гишүүдээс гадна бусад холбогдох талуудыг татан оролцуулах, хяналт тавих;

5.1.3.Нийслэлийн зөвлөлд ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэх;

5.1.4.Хуралдааны шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, тайлагнах;

5.1.5.Үндэсний болон Нийслэлийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажил, түүний явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах;

5.1.6.Үндэсний болон Нийслэлийн зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулан авах;

5.1.7.Гамшгийн эрсдэлийг бууруулах дүүргийн зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааны жилийн тайланг гаргуулах;

5.1.8.Нийслэлийн зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах

Зургаа.Бусад

6.1.Нийслэлийн зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Онцгой байдлын газрын төсвийн хүрээнд санхүүжүүлнэ.

6.2.Нийслэлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан арга хэмжээний зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.3-т заасны дагуу бүрдүүлж, тухайн жилийн төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.